

ЖАЛАЙЫР

*М.Хурметхан**

Сүүлд, үндэстэн болж бүрэлдсэн эртний овог аймгийн тухай аман сурвалж, бүр сурвалж бичгийн мэдээ баримтанд итгэхэд бэрх байдаг. Аман түүх өгүүлэгчид, гарваль үүслийн тухай яригчид өөрсдийнхөө өвөг дээдсийн тухай нэлээд хожуу үеийн талаар өгүүлж, өвөг дээдсийн хөрш, үгүй бол холилдон суусан овог аймагтай хамаатан садан болгоно. Тэгэхдээ, тухайн нутаг дэвсгэрт аж төрж байсан хүмүүс, тухайн овог аймгийн түүхийг үл салган өгүүлдэг нь үнэнээс хол зөрүү байдаг. Бие даасан овог, аймаг, үндэстэн нь нэг эцэг эхээс гаралтай байх магадалалтай, мөн тийм биш ч байх боломжийг агуулдаг билээ. Төв Азид нутагласан үндэстэн, овог аймгууд янз бүрийн үед, түүхийн янз бүрийн нөхцөлд үүсэн бий болсон бололтой бөгөөд түүхэнд харилцан адилгүй товойн мандаж, харилцан адил, адилгүй түүхэн замыг туулсан байна. Тэдний гарал үүсэл, итгэл үнэмшил, аж ахуй, хэл соёлыг дагалдан антропологийн хэсгүүд үүсчээ. Бид энэ бүхнийг биш дундад эртний түүхэнд тэмдэглэгдсэн Жалайыр аймгийн гарал үүслийн байдал, дараагийн хувь тавилангийн талаар өгүүлэх болно.

Сүүлийн жилүүдэд А.Ш.Кадырбаевын “Очерки историй средневековых уйгуров, джалайыров, найманов и керейтов” (А;1993), Бек Тогысов “Эрт ба эдүгээ” (А., 2003) зэрэг зохиолуудад Жалайыр аймгийн тухай өгүүлжээ. Гол нь Жалайыр аймгийн гарал үүслийн талаар эрдэмтэд харилцан адилгүй санал дэвшүүлсэн байдаг байна. Эдгээр нь голдуу Жалайырыг түрэгжсэн “монгол” гэх буюу ямар гаралтай нь тодорхой биш гэсэн байдалтай таамаглал маягтай саналтай байдаг. Жалайыр аймгийн нэр нь Киданы үеэс мэдэгдэн тэмдэглэгдсэн байна. “История МНР” (М; 1983) гэсэн номонд Хэрлэн ба Ононгийн хоорондох нутагт Жалайыр нар нутаглаж байсан нь тэмдэглэгджээ. (с.117)

ҮШ зууны үед хамаарах “Таншу”-гийн мэдээгээр Карлукуудын бүрэлдэхүүний гурван том овгийн холбоог моула, чжиси болон ташили гэжээ. (История Казахской ССР., А., 1977. т.2, с.338, 342, 19, 15, 29, 75, 107, 242, 243) Моула нь Булаг омгийг тэмдэглэсэн хийгээд Махмуд Кашгари түрэг угсааны булаг, алка булаг гэсэн овог байсныг тэмдэглэжээ. Карлукуудын өөр

* М.Хурметхан - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

нэг аймаг нь чжисы нь чигиль (джикалей) гэжээ. (История Казахской ССР., А., 1977. т.2, с.14, 15, 29, 117, 243)

XIV зуунд Жалайыр нар “жете-чете” хэмээх нэрээр тодорхой байж, Дундад, Баруун Азийн түүхэнд чухал үүрэг гүйцэтгэжээ. Казахын Жалайыр аймгийн тухай КСЭ-д (боть 4. т.230)-д тодорхой өгүүлжээ. Эдгээрээс үзэхэд Төв Ази, Цагаагайн улс, Иран, Ирак, Казахстан, Армени төдийгүй Хятад, Вьетнам гэх мэт орнуудад Жалайыр угсаатны төлөөлөгчид томоохон үүрэг гүйцэтгэжээ. Гэхдээ эдгээр нь XII зуунаас хойшхи түүх юм.

Харин XII зуунаас өмнөх Жалайыр нарын түүхийг авч үзвэл; тэд Чингис хаанд сайн дураар дагаар орсон байна. Жалайырын жаг овгоос гаралтай Мухулай нь Чингис хааны итгэлт жанжны нэг нь байв. (Рашид-Ад-Дин “Жами Ад Тауарих” т.150)

Монголын өндөрлөгт дундад зуунд аж төрж байсан бусад овог, аймгийн адил Жалайыр аймгийн гарал үүслийн тухай түүхийн шинжлэх ухаанд хэд хэдэн таамаглал маягийн санал байна. Тухайлбал, Рашид-Ад-Дин, М.Кашгари, А.Жувейни, В.В.Бартольд, Ш.Уалиханов, Г.Е.Грум-Гржимайло гэх мэт эрдэмтэд Жалайырыг монгол хэлтэн аймаг гэсэн бол Н.Аристов, Н.Румянцев, Н.А.Абрамов, С.Аманжолов, В.В.Востров, М.С.Муханов гэх мэт эрдэмтэд түрэг хэлтэн аймаг байсан гэж баталж байна. (Казахын килы тарихы “Жалын” 1992.т.184-190).

Чингис хаанаас өмнө түрэг овог аймгуудыг хятад сурвалж бичигт “сему” хэмээн нэрлэж, тэд хонин юмуу цэнхэр нүдтэй, арьсны будаг нь шар юмуу шаргал байсныг тэмдэглэжээ.

Ю.А.Зуев бичихдээ, Жалайыр аймаг нь Чингис хаанаас өмнө Хархорины орчим уулаар, Орхон голын Сэлэнгэд цутгах цутгалан хавиар нутагладаг хүмүүс байсан гэжээ. (Ю.А.Зуев “Жами ат Тауарих” Рашид ад-Дина источных по ранней истории Жалайыров” с.178-185)

Тэд Найман, Керай, Онгуудын адил эсгий гэрт аж төрж байжээ. А.Г.Галаян “Армянские источники о монголах” (М.1962.с.41) гэсэн бүтээлд “эд нар хүн амын тоо их, их хүчирхэг аймаг Жалайыраас гаралтай юм” гэжээ. Харин Рашид-Ад-Дин “Жалайыр нар арван том хэсгээс бүрдэнэ, тэдний тус бүр нь том ард түмнийг бүрдүүлсэн” гэжээ. (Рашид-Ад-Дин т.1 кн 1. с-93) Жалайыр нарын эртний түүх нь Огуз, Карлук, Енисейн Киргиз нартай холбоотой бололтой. Учир нь арслан цолыг карлукын чигил, харин буур цолыг иагма нар эзэлдэг байв. Харин иагма нарын дараагийн үе нь Жалайыр аймаг юм. Кадыргали Жалайыри

“Жамиат Тауарих” номондоо өөрөө Жалайыр гаралтай хүн тул гарал үүслийнхээ түүхийг Огуз хаанаас Чингис хаан хүртэлх үеийг бичиж үлдээсэн байдаг. Жалайыр аймаг Огузын Дулу, Чумугун аймгийн хамтаар Дорнод Түрэгийн хаант улсын бүрэлдэхүүн байсан тухай тэмдэглэжээ. Экзоэнтнонимийн хувьд Жалайыр нь Жал-айыр хэмээн задрах боломжтой бөгөөд Жал нь бол үндсэн гол, ай, айыр нь салаа, овог омог, отог гэсэн санааг заасан байдалтай юм. Энэ нэр нь Тувагийн Конгр-ай, Хакасын Хонгир-ай, Киргизийн Хоор-ай болон Сагай, гэх мэт угсаатны нэртэй үгийн гарлын хувьд нэгтэй байх боломжтой юм. Рашид ад-Дин Жалайырын 10 овгийг жаит, кункауйт, оймауйт, куркин, токрауйт, кумсауйт, нилкин, тулапкт, санкауат гэжээ. Жалайырын куркин (кыркын) овог нь орхоны түрэг бичээст тэмдэглэгдсэн курыкан буюу уч-курыкантай (одоогийн саха-якут) (Мелиоранский, Памятник в честь Кюльтегина, ЗВО, т. XII вып, I, II, III и IV с. 28, 32, 41) ижил байгаа нь харагдаж байна.

Керайн жыркын (Аристов хыр-хын гэжээ), Жалайырын куркин бараг адил дуудлагатай бол Керайн сахыят, тонхаит, тубаут, албат овгийн нэр Жалайырын овгуудын нэрийн төгсгөл адил байгаа нь анхаарал татаж байна.

Чингис хаанаас хойшхи Жалайыр аймгийн түүх тодорхой бөгөөд тэд 4 том хэсэг болон салжээ. Нэгдүгээр хэсэг үндсэн гол хэсэг нь Төв Азид үлдсэн: хоёр дахь хэсэг хүн ам, эд хөрөнгийн хамт Зүчийн харъяанд орж Шу голын дунд урсгалаар шуманах-шуг манаагчид нэртэйгээр суурьшсан. Гуравдугаар хэсэг Шыршыкийн талд (сырманах нэртэйгээр) суурьшиж, сүүлд Жалайырын Ордыг бүрдүүлсэн, дөрөвдүгээр хэсэг нь Хүлэгү хааны хамт Перс (Иран)-д очиж нутагласан байна. Жалайырийн нэрт түүхч Кадыргали Жалайырийн бичсэнээр Зүчийн улсын Жалайыр нар ХҮІ зуунд Улытау, Көкшетау уулын завсар нутагт суурьшсан байна. 1757-1758 онуудад Зүүнгарын Алатау, Или, Каратау хүртэл тархан суурьшив. Өзбек, Каракалпах, Монгол, Киргизийн Жалайыр нар тэр ард түмнүүдийн бүрэлдэхүүний хувиар түүхээ үргэлжлүүлсэн байна.